



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох,  
актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт  
хийх, тайлан гаргах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 331 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Нацагдорж/-нд даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ  
ДЭД ДАРГА  Э.БАТБОЛД



000100